

# ШИНЭ ОЮУТНЫ ЧИГЛҮҮЛЭХ СУРГАЛТ

## СҮРЬЕЭГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ИЛРҮҮЛЭХ ҮЗЛЭГИЙН ЗААВАР

Сүрьеэг эрт илрүүлж, цаг тухайд нь эмчилбэл бүрэн эдгэрэх боломжтой.

Бид бүгдийн эрүүл мэндийн төлөө урьдчилан сэргийлэх арга хэмжээнд анхаарч, зөвлөмжийг сайтар дагаж мөрдөнө үү.



### 1 Сүрьеэ гэж юу вэ?

- Сүрьеэ нь сүрьеэгийн нян (*Mycobacterium tuberculosis*)-аас үүсдэг халдварт өвчин юм.
- Өвчтэй хүн ханиах, найтаах эсвэл ярих үед агаарт тархах бичил дусал, тоосонцроор голчлон халдварладаг.



### 2 Сүрьеэг сэжиглэх шинж тэмдэг

Дараах шинж тэмдгүүд 2 долоо хоногоос дээш хугацаанд үргэлжилбэл сүрьеэг сэжиглэж, шинжилгээнд хамрагдана уу!



2 долоо хоногоос дээш үргэлжилсэн ханиалга



Халуурах



Шөнө хөлрөх



Жин буурах



Цээжний рентген зурагт өөрчлөлт илрэх

### 3 Шинжилгээний дараалал болон хаана хандах



Асуумж авах, бүртгэх



Цээжний рентген шинжилгээ



Цэрний шинжилгээ (шаардлагатай тохиолдолд)



Шинжилгээний хариуг шалгаж, заавар зөвлөгөө авах

① Эмнэлгийн байгууллага (зардлыг өөрөө хариуцна)

② Нийтийн эрүүл мэндийн төв (үнэ төлбөргүй)

- Очихоосоо өмнө заавал урьдчилан холбогдож лавлана уу.
- Ажлын өдөр 09:00~18:00

### 4 Сүрьеэгээс урьдчилан сэргийлэх дүрэм

Амны хаалт зүүх



Ханиалгах зэрэг амьсгалын замын шинж тэмдэг илэрвэл амны хаалт зүүнэ үү.



Ханиалгах зөв дадлыг мөрдөх

Ханиах, найтаах үедээ ам, хамраа салфетка эсвэл ханцуйгаараа дарна уу.



Тогтмол агаар сэлгэх

Өрөө тасалгааны агаарыг тогтмол сэлгэж, цэвэр агаартай таатай орчныг хадгална уу.

### 5 Зардлын мэдээлэл

#### Дэмжлэгийн тогтолцоо

Сүрьеэгийн эмчилгээ шаардлагатай тохиолдолд эмчилгээ болон эмийн зардлын дэмжлэг зэрэг төрөл бүрийн дэмжлэг авах боломжтой.



### 6 Холбоо барих



- Бүчон хотын Нийтийн эрүүл мэндийн төвийн 365 дуудлагын төв: 032-320-3000
- Католик их сургуулийн Бүчон Гэгээн Мариагийн эмнэлгийн лавлах утас: 1577-0675



가톨릭대학교  
THE CATHOLIC UNIVERSITY OF KOREA